



Төрийн Бус Байгууллага

Байгууллагын танилцуулга:

- Улаанбаатар хотод 1997 онд эрсдэлт бүлгийн охид эмэгтэйчүүдийн төлөө, тэдэнд эрүүл мэндийн халамж үйлчилгээ үзүүлэн ажиллахад хувь нэмрээ оруулахаар эмэгтэй биеэ үнэлэгч олон нийтэд түшиглэн үүсгэн байгуулагдсан.
- 1998-2004 онд ДОХ-той тэмцэх үндэсний сан, Альянса олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр “Итгэл” төслийг Улаанбаатар хотын эмэгтэй биеэ үнэлэгчдийн дунд ХДХВ, ДОХ, БЗДХ-аас сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж эхэлсэн. Төслийн менежер, 2 хүрч очих ажилтантай ажилласан.
- 2004 оноос “Итгэл шүтээн” ТББ болон 1 төслийн менежер, 1 эмч, 2 хүрч очих ажилтантай ажилласан.
- 2011 оноос Улсын бүртгэлийн ерөнхий газраас хуулийн этгээдийн нэр давхардан бүртгэгдсэн учир “Төгс бүсгүйчүүд” Төрийн бус байгууллага болон ажиллаж байна.
- 2004-2007 онд ДОХ-той тэмцэх үндэсний сангийн дэмжлэгтэй эрсдэлт бүлгийн эмэгтэйчүүдийн хөтөлбөрийг хэрэгжүүлсэн.
- Глобаль сангийн 2008-2011 онд “Эрсдэлт бүлгийн хүн амд чиглэсэн ХДХВ, ДОХ-оос сэргийлэх, эмчилгээ, тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, чанаржуулах, эрүүл мэндийн салбарын чадавхийг бэхжүүлэх замаар ХДХВ-ийн халдварын бага тархалтыг тогтоон барих” төслийн хэрэгжүүлэгч байгууллагаар ажилласан.
- Глобаль сангийн 2011-2014 онд “ХДХВ, ДОХ, БЗДХ-аас сэргийлэх Үндэсний хөтөлбөрийг өргөжүүлэх замаар Монгол улсад ХДХВ-ийн халдварын бага түвшинг тогтоон барих” төслийн хэрэгжүүлэгч байгууллагаар Улаанбаатар хотын 6 дүүрэг болон орон нутагт дэд салбар хүлээн авагч Дархан-Уул, Орхон, Дорнод, Сэлэнгэ, Дорноговь аймгийн төрийн бус байгууллагуудтай хамтран хэрэгжүүлсэн.
- Глобаль сангийн 2015-2017 онд “ХДХВ, ДОХ, БЗДХ-аас сэргийлэх Үндэсний хөтөлбөрийг өргөжүүлэх замаар Монгол улсад ХДХВ-ийн халдварын бага түвшинг тогтоон барих” төслийн хэрэгжүүлэгч салбар хүлээн авагчаар ажилласан. Эмэгтэй биеэ үнэлэгч болон тэдний үйлчлүүлэгчдэд чиглэсэн урьдчилан сэргийлэх хөтөлбөрийг дэд салбар хүлээн авагчаар орон нутагт Дорноговь аймгийн “Чуулсан үгс”, Дархан-Уул аймгийн “Эмэгтэйчүүдийн Итгэл найдвар холбоо”, Орхон аймгийн “Эрхэмсэг оршихуй Эрдэнэт”, Сэлэнгэ аймгийн “Хатан замнал”, Дорнод аймгийн “ЛЭОС”, Баянхонгор аймгийн “Хонгорын төгс тэмүүлэл”, Өмнөговь аймгийн “Говийн ухаан”, Хөвсгөл аймгийн “Төгс зохицол-Гэр бүл, Ховд аймгийн “Түгээмэл орчлон” ТББ-уудтай хамтран хэрэгжүүлсэн.

- Глобаль сангийн 2018-2020 оны “ХДХВ, ДОХ, БЗДХ-аас сэргийлэх Үндэсний хөтөлбөрийг өргөжүүлэх замаар Монгол улсад ХДХВ-ийн халдварын бага түвшинг тогтоон барих” үргэлжлэх шатны төслийн хэрэгжүүлэгч салбар хүлээн авагчаар ажиллаж байна. БНХАУ, ОХУ-тай хил залгаа оршдог Дорноговь, Сэлэнгэ аймгийн “Чуулсан үгс”, “Хатан замнал” ТББ-уудыг дэд салбар хүлээн авагчаар үргэлжлүүлэн сонгон хамтран ажиллаж байна.
- “Төгс бүсгүйчүүд” ТББ-ын удирдах зөвлөл 7 гишүүнтэй. Төсөл хэрэгжүүлэх баг нь гүйцэтгэх захирал, төслийн менежер, хяналт-шинжилгээ үнэлгээний мэргэжилтэн, их эмч, нягтлан бодогч, кейс менежер болон 7 хүрч очих ажилтантай, хамтран ажиллагч орон нутгийн дэд салбар хүлээн авагч 2 аймагт 5 хүн (1 аймагт төслийн менежер 1, хүрч очих ажилтан 1-2), нийт 19 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа хэрэгжүүлж байна.

Зорилго:

Эрсдэлт бүлгийн хүн ам болох ЭБҮ-ийн дунд ХДХВ, БЗДХ-аас сэргийлэх, тусламж үйлчилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлснээр тэдний болон үйлчлүүлэгчдийн дундах ХДХВ, БЗДХ-ын тархалтыг бууруулах

Чиглэл:

- ХДХВ, БЗДХ-аас сэргийлэх мэдлэг, мэдээлэл олгох, зан үйл өөрчлөх
- Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх
- Ээлтэй орчинг бий болгох, хамтрагч талуудын оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн ухуулга, нөлөөллийн үйл ажиллагаа
- Төр болон ТББ-ын хамтын ажиллагааг бэхжүүлэх, чадавхжуулах, хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт, үнэлгээ хийх

Үйл ажиллагааны чиглэл 1: ХДХВ, БЗДХ-аас сэргийлэх мэдлэг, мэдээлэл олгох, зан үйл өөрчлөхөд чиглэсэн үйл ажиллагаа:

- Хүрч очих үйл ажиллагаа
- Үе тэнгийн сургагч бэлтгэх сургалт
- Нуугдмал олон нийтийг илрүүлэх
- Бүлгийн ярилцлага
- Идэвхжүүлэх үйл ажиллагаа
- Мэргэжил олгох сургалтанд хамруулах

Үйл ажиллагааны чиглэл 2: Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх

- Төвөөр дамжуулан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх
- Явуулын сайн дурын зөвлөгөө шинжилгээ
- Ганцаарчилсан зөвлөгөө
- ЭБҮ-дийн үйлчлүүлэгч, хамтран амьдрагч нарыг эмчилгээ, үйлчилгээнд хамруулах

Үйл ажиллагааны чиглэл 3: ЭБҮ-дэд чиглэсэн урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт, үнэлгээ хийх

- Улаанбаатар хотод хэрэгжүүлж буй ЭБҮ-д чиглэсэн цогц хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт, үнэлгээ хийх
- Хамтран ажилладаг орон нутгийн дэд салбар хүлээн авагч ТББ-уудын хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт үнэлгээ хийх, арга зүйн дэмжлэг үзүүлэх

Үйл ажиллагааны чиглэл 4: ЭБҮ-тэй ажилладаг байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх, чадавхижуулах

- Улаанбаатар хот, орон нутгийн хөтөлбөрийн ажилчдыг чадавхижуулах сургалт зохион байгуулах
- Эрсдэлт бүлгийн хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгчдэд сургалт зохион байгуулах
- ЭБҮ-г зуучлагч нарт нөлөөллийн уулзалт зохион байгуулах
- ЭБҮ-ийн үйлчлүүлэгч нарт мэдээлэл, сурталчилгааны үйл ажиллагааг зохион байгуулах

Хамтран ажилладаг байгууллагууд:

- ХӨСҮТ-ийн ДОХ/БЗДХ-ын ТСА
- ДОХ-той тэмцэх үндэсний сан
- Монголын Гэр бүл сайн сайхны нийгэмлэг
- Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага
- “Пакт” олон улсын байгууллага
- Монголын Улаан Загалмайн нийгэмлэг
- Хүйсийн Тэгш Эрхийн Төв
- “Залуус эрүүл мэнд төв”, “Хамтдаа” ТББ
- “Бутайн оргил” ТББ
- ЭМЯ, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төсөл
- НЭМГ “Сэтгэл амар” төвүүд
- Хүний хөгжил, НҮЭМ-Эрх ТББ-уудын сүлжээний гишүүн
- Ази Номхон Далайн Бүсийн ЭБҮ-дийн холбооны гишүүн байгууллага
- ЦЕГ-ын Нийтийн Хэв Журам Хамгаалах алба
- УБ хотын Цагдаагийн газар
- “Өөдрөг амьдрал” ТББ
- “Сэтгэл зүйн мэдрэмж” ТББ-уудтай хамтран ажиллаж байна.

Хамтран ажиллагч дэд салбар хүлээн авагч байгууллагууд:

- Дорноговь аймгийн Замын-Үүд сумын “Чуулсан Үгс” ТББ
- Дархан-Уул аймгийн “Эмэгтэйчүүдийн Итгэл Найдвар Холбоо” ТББ
- Дорнод аймгийн “ЛЭОС” ТББ
- Сэлэнгэ аймгийн “Хатан замнал” ТББ
- Орхон аймгийн “Эрхэмсэг оршихуй Эрдэнэт” ТББ
- Өмнөговь аймгийн “Говийн ухаан” ТББ
- Баянхонгор аймгийн “Хонгорын төгс тэмүүлэл” ТББ
- Ховд аймгийн “Түгээмэл орчлон” ТББ
- Хөвсгөл аймгийн “Төгс зохицол-Гэр бүл” ТББ

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 3-р хороо, жуулчны гудамж,
Pearl tower 4 давхарт 1, 4 тоот Утас: 77075239
tugsbusquichuudtbb@gmail.com
<https://tugsbusquichuud.mn/>

